



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 0/003

Улаанбаатар хот

Г Т

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол улсын Төсвийн тухай тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын салбарт тулгамдаж буй зорилтыг яаралтай шийдвэрлэх зорилгоор 2016 оны төсөвт тусгагдсан 1.7 тэрбум төгрөгийг дараах хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар хуваарилсугай.

A. Эрүүл мэндийн салбарт

1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн MRI аппаратын урсгал засвар хийх хөргөлтийн гелийг цэнэглэхэд зориулж 176.0 сая төгрөг;

2. 300 ортой төрөх эмнэлгийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулахад 20.0 сая төгрөг;

3. “Марс констракшн” ХХК-тай байгуулсан “Төсөв боловсруулах ажлын гэрээ”-ний төлбөрт 3.2 сая төгрөг;

4. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай Эрүүл мэнд, спортын сайдын тушаалыг хэрэгжүүлэхэд 100.0 сая төгрөг;

5. Сүрьеэ, ХДХВ/ДОХ, БЗДХ өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд 100.0 сая төгрөг;

6. Нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах, телевизийн шторк хийх, зурагт хуудас хэвлүүлэх, нэвтрүүлэг хийхэд 150.0 сая төгрөг;

7. Эрүүл мэнд, спортын салбарын ололт амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллах, нийтэд зориулсан уриалга гаргах, тусгай нэвтрүүлэг хийхэд 150.0 сая тогrog;

8. “Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай” хуулийг дагаж гарах дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад 100.0 сая төгрөг;

9. “Эрүүл ахуйн тухай” хуулийг дагаж гарах дүрэм журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад 50.0 сая төгрөг;

10. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарыг орон нутагт томилолтоор ажиллуулах, аймгуудын нэгдсэн эмнэлгийн эмч нарыг үндэсний төвүүдэд дадлагажуулахад 150.0 сая төгрөг;

Б. Биеийн тамир, спортын салбарт

1. Бодибилдингийн Төв Ази, Зүүн Азийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээний зардалд дэмжлэг үзүүлэхэд 40.0 сая төгрөг;

2. Пауэрлифтингийн хэвтээ шахалтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл хангах, тоног төхөөрөмж худалдаж авах, дэмжлэг үзүүлэхэд 60.0 сая төгрөг;

3. Үндэсний шигшээ багийн тамирчдын оношлогоо, эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд 45.0 сая төгрөг;

4. Хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын оношлогоо, эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд 45.0 сая төгрөг;


В. Бусад зардал

1. Эрсдэлийн нөөцөд 510.8 сая төгрөг;

2. Хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн удирдамж, төсвийн задаргааг холбогдох хууль журмын дагуу нарийвчлан боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж хэрэгжүүлэхийг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Р.Оюунханд/, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /С.Энхболд/, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Х.Бакытжан/, Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын дагуу төсөл хөтөлбөрийн удирдамж, төлөвлөгөө гэрээг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/ нарт үүрэг болгосугай.

САЙД



С.ЛАМБАА